

ОВООТЫН ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫГ
ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгальд ээлтэй

Орон нутагт өгөөжтэй



**ХУРГАТай
ХАЙРХАН**

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН НУТАГТ
БАЙРЛАХ ОВООТЫН ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-017098/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 5104424/

БОЛОВСРУУЛСАН:

“ХУРГАТАЙ ХАЙРХАН” ХХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА:

...../Ц.БАТХҮҮ/

“ХУРГАТАЙ ХАЙРХАН” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕР:

...../Г.ГҮНБАТ/

АГУУЛГА

1	Төслийн товч танилцуулга	2
1.1	Төслийн ерөнхий төлөвлөгөө	3
1.2	Төслийн 2026 оны төлөвлөгөө, хамрах хүрээ	3
1.3	Төслийн талбай	4
2	Төслийн талбайн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй.....	5
2.1	Байгаль орчин.....	5
2.1.1	Цаг уур, Уур амьсгалын онцлог	5
2.1.2	Агаар орчин.....	6
2.1.3	Усан орчин.....	7
2.1.4	Хөрсөн бүрхэвч	8
2.1.5	Ургамлын нөмрөг	9
2.1.6	Амьтны аймаг.....	9
2.2	Нийгэм, эдийн засаг	10
2.2.1	Хөдөө аж ахуй.....	10
2.2.2	Уул уурхай.....	10
2.2.3	Бусад	11
3	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	12
3.1	Агаарт үзүүлж болзошгүй нөлөөлөл	12
3.2	Усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	12
3.3	Ургамал, амьтанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	12
3.4	Хөрс, газрын хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	13
3.5	Хог хаягдлын нөлөөлөл	13
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	14
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
6	Хөндөгдсөн газрын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	17
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	17
9	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
10	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	19
11	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20
13	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21
14	Биелэлтийг орон нутгийн оролцогч тал, оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	21
15	“Тэрбум мод” хөтөлбөрийн мод тарих төлөвлөгөө	22
	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хавсралт	23
	ХАВСРАЛТ : Аж ахуйн нэгжийн гэрчилгээ.....	24
	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ.....	24
	Өмнөх онд ашиглалт эхлээгүй, үйл ажиллагаа явуулаагүй тухай тодорхойлолт	25
	2026 оны уулын ажлын төлөвлөгөө.....	26

1 Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:

Овоотын коксжих нүүрс дараах төслүүдийг хамрана :

- (i) Овоотын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах;
- (ii) Овоотын ордыг түшиглэн барих нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ)
- (iii) Овоотоос Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто замын төсөл

Дээрх төслийн бүтээн байгуулалт ашиглалтын MV-017098 тоот лицензийн талбай дотор болон хатуу хучилттай авто замын трассын хүрээнд явагдах бөгөөд бүтээн байгуулалтын ажил хараахан эхлээгүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч:

“Хургатай хайрхан” ХХК

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот-15170, Чингэлтэй дүүрэг-1-р хороо, Бага тойруу-17, Жи жи цамхаг 9-р давхар

Улсын бүртгэлийн дугаар:

9019053077

Регистрийн дугаар:

5104424

Овоотын нүүрсний уурхайн ашиглалтын MV-017098 тоот лицензийн талбайд явагдах чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн БОННУ 2022 оны 11 дүгээр сард батлагдсан. (Тайлангийн дугаар: 2020/Б-138)

Овоотын нүүрсний уурхайн ашиглалтын MV-017098 тоот лицензийн талбайд байгуулагдах Овоотын ордыг түшиглэн барих нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ)-ийн БОННУ 2024 оны 4 дүгээр сард батлагдсан (Тайлангийн дугаар 2023/СН-42).

Мөрөн-Улиастай замаас Овоот төсөл (Могой голын уурхай) чиглэлийн автозамамын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2024 оны 3 сард батлагдсан. (Тайлангийн дугаар 2023/3А-53).

Овоотын коксжих нүүрсний төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Овоотын нүүрсний төслийн инженерийн төлөвлөлт, Овоотын нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын суурь ажил, хатуу хучилттай замыг барихад байгаль орчны шаардлагуудыг биелүүлэх зорилгоор бэлтгэсэн бөгөөд нийтлэг болзошгүй нөлөөлөл түүний хяналтын арга хэмжээг уялдуулан тодорхойлсон болно.

Уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дээрх батлагдсан БОННУ тайлан түүний менежментийн төлөвлөгөөнд нийцүүлж, Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн

төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ыг баримтлан байгаль орчны хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, компаний тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг сум орон нутгийн холбогдох талуудад тайлагнах зорилготойгоор боловсруулав.

1.1 Төслийн ерөнхий төлөвлөгөө

Овоотын коксжих нүүрсний төсөл нь MV-017098 тоот ашиглалтын лицензийн талбайн хүрээнд жилд ойролцоогоор 1.5 сая тонн түүхий нүүрсийг ил уурхайн аргаар олборлож, уг нүүрсийг газар дээр нь боловсруулан 1.2 сая тонн орчим угаасан коксжих нүүрсийг борлуулахаар төлөвлөж байна. Мөн хатуу хучилттай Овоотоос - Мөрөн чиглэлийн авто замын төсөл орсон болно.

Овоотын нүүрсний уурхай болон Овоотын нүүрс баяжуулах үйлдвэрийн барилга угсралт зэрэг ажлыг олон улсын жишигт нийцүүлэн, Монгол Улсын хууль, тогтоомжийн шаардлагыг хангахаас гадна илүү чанартай гүйцэтгэхээр төлөвлөж байна.

1.2 Төслийн 2026 оны төлөвлөгөө, хамрах хүрээ


Овоотын коксжих нүүрсний төсөл нь 2025 онд олборлолт, боловсруулалттай холбоотой ямар нэгэн барилга байгууламж, ашиглалтын ажил хийгдээгүй байдаг. 2026 онд төслийн барилга байгууламж зураг төсөл боловсруулах, зарим талбайн судалгааны ажлыг эхлүүлэх төлөвтэй байна. MV-017098 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд одоогоор зөвхөн ажилчдын кемп, оффисын барилга байгууламжтай байна. Төлөвлөгөөт онд ирэх онд хийгдэх зарим барилгын ажлын бэлтгэл, байгаль орчны хяналт, олон нийттэй харилцах болон мэдээлэл түгээх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

“Хургатай Хайрхан” ХХК нь 2026 онд Овоотын коксжих нүүрсний төслийн бүтээн байгуулалттай холбоотой төлөвлөгөө, мөн шинэ кемпийн ажил болон зөвшөөрлүүдийг (дагалдах дэд бүтэцтэй холбоотой), төслийн бүтээн байгуулалтыг дэмжих санхүүжилтийг босгох, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор барилгын ажлын гэрээ, хэлэлцээр хийхээр ажиллаж байна. Энэ жил гэрээ хэлцэлүүд хийгдсэн тохиолдолд төслийн талбайд барилга байгууламжийн ажил 2026 оны 3-р улирлын эхний сар эхлэх төлөвлөгөөтэй байна.

Тухайлбал 2026 онд төслийн барилга байгууламж бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хонот 200 м³ ахуйн бохир ус цэвэрлэх хүчин чадалтай Цэвэрлэх байгууламж, Усан хангамжийн дэд бүтэц түүндээ технологи болон хурын ус цуглуулах 450 000м³ усан сангийн далангийн зураг төслийг боловсруулан батлуулж, барилгын ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй байна.

1.3 Төслийн талбай

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн байршил нь Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төв Халбангаас урд зүгт 22 км, Могойн голын нүүрсний уурхайн зүүн талд (Зураг 1) байрладаг.



Зураг 1: Төслийн байршил

2 Төслийн талбайн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй

2.1 Байгаль орчин

2.1.1 Цаг уур, Уур амьсгалын онцлог

Төслийн талбай нь уур амьсгалын мужлалаар хангайн уулархаг бүсийн чийглэгдүү хүйтэвтэр зунтай, хахир өвөлтэй мужид хамаарна. Нарны нийлбэр цацраг 1,200 кВт цаг/м² буюу нийлбэр цацрагаар Монгол орны хамгийн бага бүсэд оршдог. Хоногийн дундаж температур +10°C-аас дээш байх өдөр 75 байдаг. Нар гийгүүлэх нийт хугацаа 2,700-3,000 цаг бөгөөд өвлийн өдөр 5 цаг, зуны өдөр 9 цаг орчим үргэлжилнэ. -30°C аас доош хүйтэн өдөр 50-60 байдаг бол +30°C-аас халуун байх өдөр 20-оос хэтэрдэггүй. Цэцэрлэг сумын нутаг Овоот орчимд агаарын дундаж температур XI-III сард -14.1°C аас -29.1°C, IV-X р сард -3.3°C-аас +15.4°C-ийн хооронд хэлбэлзэнэ. Хамгийн дулаан сар нь VII сар бөгөөд дунджаар 15.4°C байдаг. Хамгийн хүйтэн сар нь I сар бөгөөд 29.1°C байдаг байна. Хамгийн бага температур нь I сард -40.6°C, хамгийн их температур нь VII сард +30.0°C байдаг.

Улирлын хэлбэлзэл: Уур амьсгалыг бүрэлдүүлэх хүчин зүйлс дотроос хамгийн их нөлөөлдөг нь газрын гадаргын жигд бус байдал буюу хотгор гүдгэрийн ялгаа байдаг. Тусгай зөвшөөрлийн талбайн хойд талд Овоот толгой, баруун талд Бүрхээр уул зэрэг 1920-2064 м хүртэл өндөртэй уулс, тэдгээрийн хоорондох нарийн хөндийнүүдтэй, уулсын орой бөмбөгөрдүү хэлбэртэй. Төслийн талбайн зүүн урд талд Могойн голын голидрол байдаг ба баруун урдаас зүүн хойш сунаж тогтсон хөндийгөөр Тэсийн голтой нийлдэг. Төслийн талбайн зүүн урд талд байрлах Могойн голын гольдрол нь хур тунадас ихтэй жилүүдэд урсац гадарга дээр ил гарч ирдэг ба бусад үеүүдэд газар доогуур шурган, урсац үзэгдэхээ больдог. Төслийн талбай нь уур амьсгалын мужлалаар хангайн уулархаг бүсийн чийглэгдүү хүйтэвтэр зунтай, хахир өвөлтэй мужид хамаарна. Нарны нийлбэр цацраг 1,200 кВт цаг/м² буюу нийлбэр цацрагаар Монгол орны хамгийн бага бүсэд оршдог. Хоногийн дундаж температур +10°C-аас дээш байх өдөр 75 байдаг. Нар гийгүүлэх нийт хугацаа 2,700-3,000 цаг бөгөөд өвлийн өдөр 5 цаг, зуны өдөр 9 цаг орчим үргэлжилнэ. -30°C-аас доош хүйтэн өдөр 50-60 байдаг бол +30°C-аас халуун байх өдөр 20-иос хэтэрдэггүй. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын цаг уурын Чандагат өртөөний мэдээгээр агаарын дундаж температур XI-III сард -11.7°C-аас 27.8°C, IV-X-р сард -3.1°C-аас +15.3°C-ийн хооронд хэлбэлзэнэ. Хамгийн дулаан сар нь VII сар бөгөөд 38 жилийн дунджаар 15.4°C байдаг. Хамгийн хүйтэн сар нь I сар бөгөөд дунджаар -40°C байдаг байна. Хамгийн бага температур нь I сард -40°C, хамгийн их температур нь VII сард +30°C байна.¹

¹ Овоот чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны төлөв байдлын тайлан-2025

Өвөл: Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт өвлийн улирал дунджаар 10-р сарын сүүлчээс 11-р сарын эхээр эхэлж, 4-р сарын эхэн хүртэл үргэлжилдэг ба нийт 150-170 хоног үргэлжилдэг. Өвлийн улиралд цаг агаар гол төлөв цэлмэг, тогтуун боловч маш хүйтэн, цасан бүрхүүл удаан хугацаанд тогтдог. 1-р сарын дундаж агаарын температур $-22\text{--}28^{\circ}\text{C}$, зарим жилүүдэд $-35\text{--}40^{\circ}\text{C}$ хүрч хүйтэрдэг. Өвөлд 10–20 мм орчим хур тунадас унадаг бөгөөд энэ нь ихэвчлэн нунтаг цас байдлаар орно. Температурын огцом хэлбэлзэл ажиглагдаж, хөрс гүн хөлддөг онцлогтой.

Хавар: Хаврын улирал 3-р сарын сүүлчээс 4-р сарын дунд хүртэл аажмаар эхэлж, 5-р сарын сүүл хүртэл үргэлжилдэг бөгөөд нийтдээ 60 орчим хоног үргэлжилнэ. Энэ үед хоногийн дундаж агаарын температур 0°C -ыг давж эхлэх боловч өдөр, шөнийн температурын ялгаа ихтэй, огцом өөрчлөлттэй байдаг. Салхины хурд хаварт нэмэгдэж, тоосжилт, хуурайшилт ихэсдэг. Дундаж салхины хурд 4.5–6 м/с, хүчтэй салхи зарим үед 15–20 м/с хүрнэ. Агаарын чийгшил багасаж, хуурайшилт нэмэгдэх нь ойн түймэр, тоосон шуурганы эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Зун: Цэцэрлэг суманд зуны улирал 6-р сарын эхээр эхэлж, 8-р сарын сүүлч хүртэл үргэлжилдэг бөгөөд нийт 80–90 хоног орчим үргэлжилдэг. 7-р сарын дундаж агаарын температур $14\text{--}18^{\circ}\text{C}$, зарим 2-11 Хургатай Хайрхан ХХК-ийн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт орших Овоот чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тодотгол тайлан -2025 Байгаль орчны төлөв байдал халуун өдрүүдэд 25°C -г давах тохиолдолтой. Жилийн хур тунадасны 60–70% нь зун ордог бөгөөд 6-р сараас наймдугаар сар хүртэл хур бороо ихтэй байдаг. Хур тунадасны хэмжээ жилийн хувьд 200–300 мм орчим ба үүний дийлэнх нь зун тохионо. Уулын бүсэд богино зуны улиралтай бөгөөд хөрс оройтож гэсэж, газрын чийгшилт их байдаг.

Намар: Намрын улирал 9-р сарын эхээр эхэлж, 10-р сарын дунд гэхэд дуусдаг бөгөөд 40–50 хоног үргэлжилдэг. Цаг агаар аажмаар сэрүүсэж, 9-р сарын сүүлээр шөнийн хяруу үзэгддэг. 10-р сарын 10-аас хойш хоногийн дундаж температур 0°C -ыг дайрч хүйтэрдэг. Салхи, хуурайшилт нэмэгдэж, хур тунадас эрс багасна — намрын эхний сард 3–8 мм орчим хур тунадас унадаг. Намар бол өвөлжилтийн бэлтгэл үе учир цаг агаарын тогтворгүй байдал анхаарах шаардлагатай нөхцөл болдог.¹

2.1.2 Агаар орчин

Хөвсгөл аймгийн Мөрөн, Хатгал орчмын 2015–2025 оны агаарын чанарын мэдээгээр хүхрийн давхар исэл (SO_2)-ийн жилийн дундаж агууламж $0.003\text{--}0.012\text{ мг/м}^3$, азотын давхар исэл (NO_2)-ийн агууламж $0.006\text{--}0.014\text{ мг/м}^3$ хооронд хэлбэлзсэн нь MNS 4585:2016 стандартад заасан

зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс ($\text{SO}_2 - 20 \text{ мг/м}^3$, $\text{NO}_2 - 40 \text{ мг/м}^3$) хэд дахин бага байгаа бөгөөд агаарын чанар нийтэд нь харьцангуй сайн, стандартад нийцсэн байна. ²

Төслийн талбай одоогийн байдлаар эзлүүд, агаарын чанар бага зэрэг хэлбэлзэлтэй байна. Учир нь төслийн талбайн баруун хойно байрлалтай Могойн голын уурхайгаас салхины аясаар тоосжилт үе үе ажиглагдана. Мөн тус Могойн голын уурхайн шороон замын дагуух машин тээврээс бага зэрэг тоосжилт ажиглагддаг байна.

2.1.3 Усан орчин

Гадаргын ус: Овоотын нүүрсний уурхайг ашиглах төсөл хэрэгжих бүс нутаг нь Төв Азийн гадагш урсацгүй ай савд буюу Увс нуур-Тэс голын сав газарт харьяалагдана. Уг сав газар нь Увс нуурын ай сав, түүний гол цутгал болон Тэс голын савыг бүхэлд нь багтаасан бөгөөд засаг захиргааны нэгжээр авч үзвэл Увс, Завхан аймгуудын хойд талын сумд, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутгийг дамнан оршино. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт 2003 онд хийсэн улсын усны тоо бүртгэлээр нийт 46 гол, горхи, 33 булаг, шанд, 13 нуур тоологдсон бол 2007 онд хийсэн улсын усны тоо бүртгэлээр нийт 39 гол, горхи, 50 булаг, шанд, 4 рашаан тус тус тоологджээ. Харин бүс нутгийн хувьд гадаргын усны сүлжээ сайн хөгжсөн бөгөөд Баруун, Зүүн шандын булаг, Туруут, Ногоон, Цагаан нуур болон Тошинтын рашаан зэрэг 10 орчим гадаргын уст цэгүүд байхаас төслийн талбай орчимд буюу Тэс голын зүүн бие (баруун тал)-д Могойн гол болон Хонгор толгойн орчимд Хадатын булаг болон Ренчинжугнай, Ногоон, Туруут нуур зэрэг бага, жижиг 7-8 нуур, тойром бүхий усны илэрцүүд тус тус тааралдана.

Газрын доорх ус: Газрын доорх усны түвшний болон чанарын шинжилгээгээр гидрогеологийн хувьд Дөрөвдөгчийн гүехэн уст үе, Юрийн нэгэн төрлийн бус уст давхарга, Кембрийн шохойн чулууны уст давхарга байна. Газрын доорх ус зэргэлдээ орших могойн гол уурхай буюу Юрийн давхаргад 80 м хүртэл илрээгүй. Энд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас усаар ханаагүй байна гэдгийг илтгэж байна. Уст үеийн туршилтын мэдээний боловсруулалт бага нэвчилттэй систем болохыг харуулсан ба нүүрс агуулагч карбонатжсан давхаргад шүүрэлтийн итгэлцүүр 0.01-0.03 м/хон байна. Тухайн талбайд хийсэн судалгаагаар Дөрөвдөгчийн хурдас, Юрагийн тунамал хурдас, Кембрийн шохойн чулуу, ан цав хагарлын систем бүхий уст давхаргууд тодорхойлогдсон байна. Уурхайн талбайн төв болон зүүн хэсэг орчмын талбайд Дөрөвдөгчийн хурдас арай илүү зузаантай байх бөгөөд ул нь усны түвшнээс доош байрлах боловч ихэнх хэсэг усаар ханаагүй байдалтай байна. Зүүн зүгт хөндийн ёроол, хажуугийн хэсгээр хурдасны илүү усаар ханасан байдалтай байх ба доор нь орших Юрагийн хурдас болон Могойн гол, Тэс голтой гидравлик холбоотой байж боломжтой гэж тэмдэглэгдсэн байдаг. Уурхайн талбайн орчимд Юрагийн хурдсанд өрөмдөж, тоногдсон цооногуудад газрын

² Овоот чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны төлөв байдлын тайлан-2025

доорх усны тогтсон түвшин нь далайн түвшинээс дээш 1746-1749 м-т оршино. Юрагийн хурдасны ус илэрсэн гүн болон статик түвшин нь литологийн болон структурийн хил зааг (хагарал болон цэвдэг г.м) бүхий салангид уст үеүд байж болохыг харуулж байна.

Газар доорх усны түвшний өндөржилтийн өөрчлөлт нь Кембрийн шохойн чулуу Юрагийн хурдасны зааг нь гидравлик хаалт үүсгэж байж болохыг харуулж байна. Юрагийн хурдас болон Кембрийн шохойн чулуу нь баруун хэсэгт үндсэн хагарлын аль ч талд ус агуулсан боловч өнөөгийн байдлаар олж авсан мэдээлэл нь хил хязгаарын нөхцөл болон гидравлик холбооны талаар тодорхойлоход хангалтгүй байна. Талбайн хэмжээнд газрын доорх усны түвшний өөрчлөлт нь хагарлын нөлөөнд орж улмаар уст давхаргууд бүр харилцан адилгүй ус нэвтрүүлэлттэй болсон байж болох харуулж байна. Газрын доорх усны чанарын хувьд 2011 онд тус талбайн 7 цооногт хийсэн усны дээжлэлтийн дүнгээс харвал натри, калийн ионууд давамгайлсан гидрокарбонатын, сулавтар шүлтлэг (pH [7.2-7.9]), хатуу ус [6.2-10.3 мг/л] байна.³

2.1.4 Хөрсөн бүрхэвч

Энэ бүс нутагт газар тариалангийн хөгжилтэй холбогдуулан хөрсний судалгаа 1960 аад оноос эрчимтэй хийгдэж эхэлсэн. Эдгээр хөрсний судалгаанууд ихэвчлэн хөрсний үржил шимийн чиглэлээр хийгдсэн ба хүнд металлын мэдээлэл байхгүй байна (Почвенный покров и почвы Монголии 1984, Доржготов 2003). Мөн түүнчлэн Могойн голын нүүрсний уурхайн үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор БОННУ болон Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлын хүрээнд хөрсний судалгаанууд хийгдэж иржээ. Сүүлийн үеийн судалгааны хувьд гэвэл 2012 онд байгаль орчны төлөв байдлын суурь судалгааны ажлын хүрээнд “Эко трейд” ХХК-ний судлаачид 16 хөрсний зүсэлт бүхий нарийвчилсан судалгаа, 2019 онд “Эх Монголын байгаль” ХХК-ий судлаачид нийт 6 цэгт хөрсний дээжлэлт бүхий судалгаа, 2022 онд “Баялаг эко” ХХК-ний судлаачид “Овоотын ордыг түшиглэн барих нүүрс баяжуулах үйлдвэрийн” төслийн Байгаль орчны төлөв байдлын ажлын хүрээнд нийт 2 цэгт хөрсний үндсэн зүсэлт бүхий судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр судалгааны үр дүнгүүдийг харьцуулж харахад нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсөн бүрхэвчийн агрохимийн үзүүлэлтүүд ойролцоо буюу зөрүү багатай, мөн өнгөн хөрсөн дэх хүнд металлын агууламж хэвийн түвшинд байна.

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь ойт хээр болон хээр бүхий экосистемтэй, д.тд 1,760-1,995 м үнэмлэхүй өндөртэй тэгш өндөрлөг бүхий нам уулс болон тэдгээрийн хоорондох ам хөндийд байрлах бөгөөд харшороон, хархүрэн, бүс дундын болон аллювын хөрсний хэв шинжүүдэд багтах хужирлаг, мараалаг, бараан, карбонаттай, чулуурхаг, сайргархаг, нугархаг,

³ Овоот чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны төлөв байдлын тайлан-2025

ердийн төрлийн хөрснүүд дангаар болон бүрдэл байдлаар тархсан байна Эдгээр хөрснөөс Хархүрэн хэв шинжийн хөрснүүд талбайн 94% орчимд зонхилон тархсан байна.

Хархүрэн хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин дунд зэрэг буюу ялзмагийн агууламж нь 2-5%, хөрсний урвалын орчин 7.8-8.8 буюу хүчтэй шүлтлэг, хөрсний доод үе давхаргууд нь карбонатын агууламж өндөртэй, хөдөлгөөнт фосфор калийн хангамж багавтар, элсэнцэр болон нарийн элсэн механик бүрэлдэхүүнтэй, зарим хөрс нь хялбар уусах давсжилт ихтэй, дундаж зузаан (30-50 см) үе давхаргатай, шороон зам зэрэг техникийн нөлөөтэй эвдрэл талхагдалд дунд зэрэг тэсвэртэй байна.⁴

2.1.5 Ургамлын нөмрөг

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт орших “Хургатай Хайрхан” ХХК-ийн “Овоотын чулуун нүүрсний ордыг ашиглах” төслийн талбайн Монгол орны ургамал газарзүйн тойргоор Хангайн уулын ойт хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).

Төслийн талбай орчимд 2025 оны 6 сард хээрийн судалгаа хийж 25 овогт хамаарах 62 төрөл, 75 зүйл ургамал тэмдэглэж, өмнө хийгдсэн судалгаа, суурь судалгааг үндэслэн 28 овогт хамаарах 72 төрөл, 100 зүйл ургамал бүртгэлээ. Төслийн талбай нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө уулыг нуга, уулын хээрийн ургамалжилтай.

Төслийн талбай нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө уулыг нуга, уулын хээрийн ургамалжилтай. Төслийн талбайн ургамалжлыг 2 хэв шинж, 3 хэвшил, 6 бүлгэмдэл болгон ангиллаа. Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын хайгуулын талбай, тариан талбай, зам ургамлан нөмрөг устсан нь антропоген нөлөөлөлд өртөөсөн тул их талхагдаж доройтсон ангилалд багтаж байна. Байгалийн бэлчээр нь Сөөг бүхий Алаг өвс үетэнт бэлчээр, Үетэн-алаг өвст бэлчээр, Ерхөг-хялгана-агьт бэлчээр соргог, Алаг өвс- агь –үетэнт бэлчээр, Хялгана-агьт бэлчээр сул талхлагдсан, Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээр, атар газрын бэлчээр дунд зэрэг талхлагдсан байна.⁴

2.1.6 Амьтны аймаг

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт хэрэгжиж буй уурхайн төсөл нь байгалийн бүс, бүслүүрийн хувьд ойт хээрийн бүсэд байрлаж байгаа бол амьтны газар зүйн мужлалаар Хөвсгөлийн тойрогт хамаарна. Төслийн талбайн өмнөд хэсэг нь хуучин атаршсан газар бол зэргэлдээ Могойн голын уурхай ажиллаж байна. Амьдрах орчны хувьд хагас өөрчлөгдсөн хэв шинж илрэх бөгөөд Могойн гол, Тэсийн голын савууд, уулын ар, энгэр хэсгээр ойн сантай, баруун зүгт 20 орчим км зайд Жугнайн нуур бий. Хуучин тариалангийн атаршсан газрыг дагаж

⁴ Овоот чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны төлөв байдлын тайлан-2025

бэлчээрийн хөнөөлт зүйл болох үлийн цагаан оготно ихээр тархсан бол монгол чичүүл цөөн илэрнэ.


Төслийн талбай нь тал-хээр нутагт хамаарах бөгөөд төслийн талбайн бүх хэсэгт цайвар үлийч буюу үлийн цагаан оготно их хэмжээний үлий үүсгэн тархсан нь түүгээр хооллон амьдардаг махчин шувууд болон мах идэшт жижиг амьтад элбэг тархах нөхцлийг бүрдүүлжээ. Төслийн талбай болон түүний орчимд тохиолдох боломжтой зүйлүүд нь нийт 5 баг, 10 овогт хамаарах 14 зүйлийн хөхтөн, 1 салбар баг, 2 овогт хамаарах 4 зүйлийн мөлхөгч, 1 баг, 1 овогт хамаарах 1 зүйл хоёр нутагтан, 5 багт хамаарах 16 зүйл шувууг хээрийн судалгааны явцад болон бүс нутгийн Улаан дансны цувралууд, Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага (2014) зэрэг бүтээлийг шүүж тоймлон авч үзсэн.

2.2 Нийгэм, эдийн засаг

2.2.1 Хөдөө аж ахуй

Нутгийн иргэд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй голчлон эрхэлдэг ба газар тариалан эрхэлдэггүй. 1980-аад оны Атрын аяны хүрээнд хагалж байсан атаржсан талбай тус газарт үлдсэн бөгөөд түүнээс хойш уг талбай нь ашиглагдахгүйгээр атаршиж, байгалийн үндсэн хэв шинжээ алдсан байна. Энэхүү атаржсан талбай нь “Хургатай Хайрхан” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн 1000 орчим га талбайг эзэлдэг.

Бид Тогтвортой Хөгжлийн зорилтын хүрээнд орон нутгийн мал аж ахуйг дэмжиж, тухайн ашиглагдахгүй атаржсан талбайн зарим хэсгийг дахин сэргээж, төслийн талбайгаас зүүн тийш бага хэмжээний талбайд (200 га) ногоон тэжээл тариалах, хураах ажлыг амжилттай хэрэгжүүлж, орон нутгийн иргэдэд ногоон тэжээл тарьж болохыг харуулхын зэрэгцээ, сонирхсон иргэдэд зааж сурган, амьжиргаанд нь бага боловч хувь нэмрээ оруулсаар байна.



Мөн орон нутгаас худалдан авах боломжит бараа бүтээгдэхүүнээ худалдан авдаг бөгөөд, тэр дундаа мах, сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх чиглэлд хамтран ажилладаг.

2.2.2 Уул уурхай

Төслийн талбайн баруун талд залган “Могойн Гол” ХК-ийн нүүрсний уурхай байрладаг бөгөөд үйл ажиллагаагаа 1971 оноос хойш явуулж байна. Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчиллын комиссын 1994 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 35 дугаар тогтоолоор төрийн өмч давамгайлсан “Могойн Гол” хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

2.2.3 Бусад

Цэцэрлэг сум нь Монгол орны баруун хойд хилийн бүсэд, ОХУ-тай хиллэдэг бөгөөд Улаанбаатар хотоос хамгийн алслагдсан сумдын нэг юм. Энэ суманд дэд бүтэц, зам харилцаа сул хөгжсөн, үйлчилгээ, үйлдвэржилт хараахан хөгжөөгүй, хөдөлмөр эрхлэлт, ажлын байр дутмаг газар байдаг.

3 Гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, ан амьтан, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, олон нийтийн аюулгүй байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл тус бүрээр нарийвчлан авч үздэг.

Төлөвлөгөөт жилд төслийн талбайд дэд бүтцийн барилга байгууламж зураг төсөл боловсруулах, батлуулах цаашлаад дэд бүтцийн байгууламжуудыг барьж байгуулах, хашаа барих, өнгөн хөрс хуулалт, хадгалалт зэрэг үйл ажиллагаа явагдах юм. Төслийн талбайд ажилчдын кемп 32 гэрээс бөгөөд кемпд одоогоор дунжаар 10 хүн ажиллаж байна. Бид тухайн жилийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлов.

3.1 Агаарт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй дараах нөлөөллүүд байна. Үүнд:

- Овоотын түр кемпээс дэд бүтцийн барилга байгууламжын бүтээн байгуулалтанд ажиллах ажилчдыг тээвэрлэх тээвэр, мөн барилгын материал тээвэрлэх түр замуудаас тоосжилт үүснэ. “Тоосжилтоос урьдчилан сэргийлэх, бууруулах, арга хэмжээ болон хяналтын журам” боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж тоосжилтоос үүсэх агаарын чанарыг хянана.
- Овоотын түр кемпийн хоол үйлдвэрлэл болон ажилчдын амрах гэрүүдийн галлагаанаас бага хэмжээний үнс, тоосжилт үүснэ.

3.2 Усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Гадаргын ба гүний усанд үзүүлж болзошгүй дараах сөрөг нөлөөллүүд байна. Үүнд:

- Тухайн жилийн үйл ажиллагаанаас газрын гадарга болон гүний усанд сөрөг нөлөөлөл үүсгэхгүй.

3.3 Ургамал, амьтанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Ургамал, амьтанд үзүүлж болзошгүй дараах сөрөг нөлөөллүүд байна. Үүнд:

- Кемпийн үйл ажиллагаанаас орчны ургамал амьтанд сөрөг нөлөөлөл үүсгэхгүй.
- Кемпийн ажилчид зөөх тээврийн хэрэгсэлээр олон сал зам гарч болзошгүй тул холбогдох журмын тогтсон нэг замаар зорчих, сургалт орох.

3.4 Хөрс, газрын хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөрс, газрын хэвлийд үзүүлж болзошгүй дараах сөрөг нөлөөллүүд байна. Үүнд:

- Төслийн олборлолтын үйл ажилагаа бүрэн хэмжээгээр эхлээгүй, барилгын ажлын хүрээнд бага хэмжээний газар хөндөх үйл ажиллагаа хийгдэх тул компанийн Газар хөндөх зөвшөөрөл хүсэх журам зохицуулан ажиллах болно.
- Барилга, байгууламжын суурийн хөрсний хэв шинжийг судлах, мөн суурийн бүтээцийн ажлын хүрээнд өнгөн хөрс хуулах ажил хийгдэх тул компанийн Газар хөндөх зөвшөөрөл хүсэх журам, Шимт хөрс хуулах ба овоолго үүсгэх журам, Тоосжилтоос урьдчилан сэргийлэх, бууруулах, арга хэмжээ болон хяналтын журмаар хөрсөнд үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- Автомашины түлш, тос тосолгооны материалын асгаралт гарч болзошгүй тул асгаралтаас сэргийлэх арга хэмжээг компанийн Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, цэвэрлэх, тайлагнах журмаар зохицуулан ажиллана.

3.5 Хог хаягдлын нөлөөлөл

Кемпийн үйл ажиллагаанаас хог хаягдал үүсэх бөгөөд орчин бохирдуулж болзошгүй. Тухайлбал ахуйн хог хаягдал үүснэ:

- Кемпийн үйл ажиллагаанаас шингэн болон хатуу хаягдал үүснэ (бохир ус)
- Кемпийн үйл ажиллагаанаас энгийн ахуйн, дахивар (хоолны хаягдал, сав баглаа, шил г.м) зэрэг хог хаягдал үүсэх ба эдгээрийг компанийн Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах журмаар зохицуулна.

4 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөний гол зорилго нь төслийн төлөвлөсөн 2026 оны үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, болзошгүй нөлөөллийг баг түвшинд байлгах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах суурь бэлтгэлийг хангах, байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж түүнийг олон нийтэд илт тод мэдээлнэ.

Тухайн жилийн (Баяжуулах үйлдвэрийн БОННУ хамаарах) Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **41,924,750** төгрөг болох бөгөөд зардлын хураангуйг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Байгаль орчны хамгаалах төлөвлөгөөний зардлын хураангуй / төгрөг /

Бүлгийн №	Хамгааллын арга хэмжээ	Нийт
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-с
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	ДҮ
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	ДҮ
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	ДЗ
9	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	Ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-с
10	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	ДҮ
11	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	28,295,000
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	13,629,750
13	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-с
14	Биелэлтийг орон нутгийн оролцогч тал, оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	ДҮ
15	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих төлөвлөгөө	ДҮ
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		41,924,750

ДЗ-Дотоод зардал, ДҮ-Дотоод үйл ажиллагаа

5 Сөрөг нөллөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	• Агаарын чанарын суурин багаж суурилуулах, тогтмол хэмжилт хийх түүний цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр шийдвэрлэх.	Мониторингийн хяналтын цэгүүдэд	удаа	Хяналт мониторингийн хэсэгт тусгав	3	Ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-с	2026 оны 8 сар	Агаарын тухай хууль Дотоод журам
		• Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн журам болосвруулж түүндээ Агаарын чанарын дотоод бодлого, журмын зохицуулалтыг тусгаж, тогтмол сайжруулах.	Баяжуулах үйлдвэрийн талбай	удаа	Дотоод үйл ажиллагаа	1	-	2026 оны 8 сар	
		• Авто тээврийн замаас үүсэх тоосжилт бууруулах зам усалгааг шаардлагатай тохиолдолд хийх.	Шаардлагатай талбайд	Удаа	Дотоод үйл ажиллагаа	-	-	2026 оны 8 сар	Байгууллагын дотоод журмын хүрээнд
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	• Түр кемпийн үйл ажиллагаанд усны зөв зохистой, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор кемпийн дотоод журамд оруулах.	Түр кемп, талбай	Удаа	Байгаль орчны дотоод журмаар зохицуулагдана	Тогтмол	-	Тогтмол	MNS 900:2010 MNS 4943:2011 MNS 5668:2006
		• Зөвшөөрөгдсөн ашиглах усны эх үүсвэрт тогтмол хяналтыг хийх.	Зөвшөөрөгдсөн усны эх үүсвэр	Удаа	ДЗ	Тогтмол	ДЗ	2026 оны 8 сар	Усны тухай хууль 30.1.4
		• Ус ашиглах дүгнэлт авах гэрээ байгуулах, төлбөрийг орон нутгийн холбогдох байгууллагын дансанд төвлөрүүлнэ.	Зөвшөөрөгдсөн усны эх үүсвэр	ш	Тогтоосон тарифын дагуу	-	Тогтоосон тарифын дагуу	2026 оны 8-р сараас	МУ 3Г тогтоол № 326 Усны нөөц ашигласны төлбөр
3	Хөрсөн бүрхэвч	• Овоотын түр кемпд ирж очих автомашины хөдөлгөөнийг тогтмол маршрутаар зохицуулж, хурдны хязгаар баримтлах, хөрсний эвдрэл болон тоосжилтыг бууруулна.	Кемп	Удаа	Байгаль орчны дотоод журмаар зохицуулагдана	Тогтмол	-	Тогтмол	MNS 5916:2008 MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		• Шаардлагагүй газар хөндөхөөс сэргийлэх, шимт хөрсний овоолго, газар хөндөх журмаар зохицуулна.	Кемп	ш	Газар хөндөх дотоод журмаар зохицуулагдана	1	Дотоод зардалд	2026 оны 8-р сараас	
		• Хатуу хучилттай замын үйл ажиллагаанд ТТАМ ашиглах тохиолдолд үржил шимт	Замын трасс лагуу	Удаа	Гэрээт байгууллага хариуцна	1	Гэрээт байгууллага хариуцна	2026 оны 8-р сараас	MNS 5917 : 2008

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		хөрсийг хуулж, нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэх.							
		Хөдөлгөөнт болон суурин тоног төхөөрөмжөөс хөрсөнд асгаралт үүсэхээс сэргийлж үзлэг шалгалт тогтмол хийх, асгаралт үүссэн тохиолдолд хөрсийг цэвэрлэж арга хэмжээ авах.	Үйл ажиллагааны талбай	Удаа	Дотоод үйл ажиллагаа	1	Дотоод үйл ажиллагаа	Шаардлагатай тохиолдолд	Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, цэвэрлэх, тайлагнах журам
		Шинээр газар хөндөх тохиолдолд үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах.	Үйл ажиллагааны талбай	Удаа	Дотоод үйл ажиллагаа	1	Дотоод үйл ажиллагаа	Шаардлагатай тохиолдолд	MNS 5916 : 2008
		Газар ашиглах төлбөрийг төлөх, гэрээг дүгнүүлэх.						2027 оны 1 сар	
4	Ургамал	Шинээр газар хөндөх тохиолдолд газар хөндөх зөвшөөрлийн хуудсыг бөглөж батлуулах, төлөв байдлын зураг дарах, ургамлын ажиглалт хийх.	Үйл ажиллагааны талбай	Удаа	Дотоод үйл ажиллагаа	Тухай бүр	Дотоод үйл ажиллагаа	Шаардлагатай тохиолдолд	Байгалийн ургамлын тухай хууль
5	Амьтан	Шинээр газар хөндөх тохиолдолд газар хөндөх зөвшөөрлийн хуудсыг бөглөж батлуулах, төлөв байдлын зураг дарах, амьтны ажиглалт хийх	Үйл ажиллагааны талбай	Удаа	Дотоод үйл ажиллагаа	Тухай бүр	Дотоод үйл ажиллагаа	Шаардлагатай тохиолдолд	Амьтны тухай хууль
		Төслийн хашаанд мал, зэрлэг амьтад орохоос сэргийлж хашаа барих, хашааны бүрэн байдал шалгаж тогтмол үзлэг хийх.	Үйл ажиллагааны талбай	Удаа	Дотоод үйл ажиллагаа	2	Дотоод үйл ажиллагаа	Шаардлагатай тохиолдолд	Амьтны тухай хууль
	Нийт			Овоот ордыг Ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-с					

6 Хөндөгдсөн газрын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2026 онд барилга байгууламж, түр байгууламжуудын болон өнгөн хөрс хуулах ажлууд хийгдэх бөгөөд уул уурхайн болон том хэмжээний олборлолтын газар хөндөх үйл ажиллагаа талбайн хүрээнд хийгдэхгүй. Бэлтгэл ажлын хүрээнд барилгын суурийн барилгын ажилд хөрс хуулах, шимт хөрс хуулах ажлыг Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлсэн компанийн дотоод Газар хөндөх зөвшөөрөл хүсэх журам, Шимт хөрс хуулах ба овоолго үүсгэх журам журмуудыг мөрдлөг болгон хийнэ. Мөн хатуу хучилттай замын үйл ажиллагаанд шаардагдах ТТАМ ашиглах талбайд нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

7 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тайлант онд ил уурхайн олборлолт, боловсруулалттай холбоотой ажил хийгдэхгүй бөгөөд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг төслийн олборлолтын үйл ажиллагаа эхлэхээр шинжлэх ухааны судалгаан дээр үндэслэж хийхээр төлөвлөж байна.

8 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

2026 онд өмнөх онуудад хийгдсэн ажлуудыг үргэлжлүүлэх, төслийн талбай орчмын айлуудтай холбоо харилцаатай байх, санал хүсэлтийг сонгох, ногоон тэжээл хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

9 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Археологи, палеонтологийн судалгааны ажлын 2011, 2012 онд хийгдсэн тайлангийн үр дүнд төслийн талбайд соёлын ач холбогдол бүхий зүйл илрээгүй.

Ажилчдад соёлын өвийн талаарх мэдлэг олгох зааварчилгаанаас гадна “олдвор” олж илрүүлсэн тохиолдолд Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмаар) хамгаалах арга хэмжээ авна.

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Археологийн дурсгал	Хатуу хучилттай замын трасын дагуу археологи,	Гэрээт компани	1	1	Ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-с	2027 оны 7 сар	Соёлын өвийг хамгаалах тухай хууль



		палеонтологий н судалгаа хийх						
		Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам боловсруулж батлуулах, ажилчдад сургалт орох	Компаний ажилчид, гэрээт ажилчид	1	1	Дотоод үйл ажиллагаан ы зардалд тусгасан	Дотоод үйл ажиллагааны зардалд тусгасан	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.1 Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал № 141
2	Палеонтологий н дурсгал							
	Нийт					-	-	

10 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн үндсэн үйл ажиллагаанаас дэд бүтцийн барилга байгууламжын ажил хийгдэх бөгөөд аливаа үйл ажиллагаа нь компанийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй болон байгаль орчны менежментийн-ны дүрэм журмын дагуу хийгдэнэ. Мөн гэрээт болон туслан гүйцэтгэгч хуулийн этгээд, хувь хүн бүрт аливаа төсөл, зам барилгын ажлын онцлогт тохируулан компанийн ХАБЭА болон БОМ-ны журмын дагуу сургалтыг шаардлагатай үед нь олгоно. Мөн төслийн талбай орчимд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэн, бэлэн байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох.

11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гарах бүхий л хог хаягдлыг Овоотын уурхайн одоогийн кемпийн үйл ажиллагааны хүрээнд ангилан ялгаж, хог хаягдлыг аль болох хамгийн бага гаргах, үүссэн хог хаягдлыг ангилан ялгах, дахивар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх зэргээр хог хаягдлын менежмент төлөвлөгөөний дагуу ажил хийгдэнэ. 2026 онд Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтцийн ажил хийгдэх бөгөөд аливаа том хэмжээний уул уурхайн үйл ажиллагаа талбайн хүрээнд хийгдэхгүй.

	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
№	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Ажилчдын хотхоноос үүсэх ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялах, хогийн савны тэмдэглэгээг сайжруулах	кемп	Дотоод зардал	1	-	Дотоод зардлаар	2026 оны 7-р сар	Хог хаягдлын тухай хууль
2	Ахуйн	Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах журмыг боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах, сургалт зохион байгуулна..	кемп	Дотоод зардлаар		1	-	2026 оны 6 сар	Хог хаягдлын тухай хууль
3	Ахуйн	Цэцэрлэг сумын ЗДТГ-т хог хаягдлын хуульд заасны дагуу жилийн хураамжийг төлөх	кемп	удаа	50,000	1	50,000	2026 оны 3-12 сар	Хог хаягдлын тухай хууль
		Кемпийн үйл ажиллагаанаас үүсэх дахин ашиглах боломжгүй энгийн ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж журмын дагуу ачуулна		удаа	250,000	10	2,250,000		
		Ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжруу нийлүүлэх	Кемп	Удаа	1,733,000	15	25,995,000	2026 оны 3-12 сар	
4	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах боломжтой хаягдлыг боловсруулах үйлдвэрт нийлүүлэх..	кемп	БОХТ-ийн зааварчилгаатай хамтатган зохион байгуулах тул нэмэлт зардал гарахгүй				2026 оны 9 сард	Хог хаягдлын тухай хууль 2017-05-12 Шинэчилсэн найруулга
5		Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг тогтмол давтамжаар зохион байгуулж хяналт тавих	кемп					Тайлант оны турш	
6		Төслийн талбайд аливаа аюултай химийн бодис ашиглахгүй	кемп	-	-	-	-	-	
7	Тоо бүртгэл	Кемпийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг бүртгэж,						2027 оны 1 сар	

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	БОХ тайланд тусгаж Цэцэрлэг сумын захиргаанд хүргүүлнэ.							
Нийт						28,295,000		

12 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг жил бүр Завхан аймгийн УЦУОШТ болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийдэг ба 2026 оны хяналт шинжилгээний боломжит хугацааг тодорхойлон, төлөвлөгөөнд тусгасан болно.

	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжын тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Агаарын чанар							
	Агаарын чанарын дотоод хөтөлбөрийн хүрээнд суурин багаж байрлуулж хэмжилт хийх	Төслийн талбай орчимд	2026 оны 9 сар	1	0	Дотоод үйл ажиллагаа	Сууриан багаж суурилуулж хэмжилтийг гүйцэтгэнэ.	Агаарын тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Хөндлөнгийн байгууллагаар Агаарын чанар, дуу чимээний дотоод шинжилгээ	Агаарын чанарын Хяналтын цэгүүд	Шаардлагатай тохиолдолд	1	557,500	2,230,000	Хяналт шинжилгээний байнгын хэмжилт, судалгаа	
	Хөндлөнгийн байгууллагаар PM2.5, PM10, TSD, SO2, NO2,			1	557,500		Итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх	
							-	
2	Хөрсөн бүрхэвч							
	Хөрсний чанарын шинжилгээ Хөрсний элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, pH, давсжилт, чийгшилт, физик химийн шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P2O5, K2O, хүнд металлын үзүүлэлтүүд	Хөрсний чанарын хяналтын цэгүүд	2026 оны 8, 11 сард	2	499,000	998,000	Итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх /ГСШТ/	MNS 5850: 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
3	Усны чанар							
	Усны физик химийн шинж чанарын дэлгэрэнгүй шинжилгээ, хүнд металлын бохирдлын шинжилгээ хийх: Pb, Cr, Cd, Zn, Ni, Cu	Усны чанарын хяналтын цэгүүд	2026 оны 6, 11 сард	2	499,000	998,000	Итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх /ГСШТ/	MNS0900:2016 хүрээлэн буй орчин.
4	Гадаргын болон газрын доорх усны хэмжилт	Уст цэгүүд	2026 оны 8-11 сард	2	Дотоод үйл ажиллагаа		Төслийн ОХШХ	ОХШХ
5	Байгаль орчны хяналт шинжилгээнд ашиглах багаж төхөөрөмж худалдан авах		2026 оны 8-р сар	1	9,403,750 Бусад Ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-с			
	Нийт					13,629,750		

Д3-Дотоод зардал



13 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

2026 оноос эхлэн төслийн зарим дэд бүтцийн ажлууд эхлэхтэй уялдуулан төслийн үйл ажиллагаанд Менежментийн тогтолцооны стандартуудыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Мөн түүнчлэн ЭМААБО-ны цогц сургалтуудыг хийхээр төлөвлөв:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцсан албан тушаалтан	Зохион байгуулах алба	Тайлбар
1.	Нэгдсэн менежментийн тогтолцоо – Шаардлага, бүтэц, ач холбогдлыг танилцуулах сургалтад ажилчдыг хамруулах	~1,500,000	2026 оны 8 сар	Тогтвортой хөгжлийн хэлтэс (ТоХХ)	ТоХГ	Байгууллагын чанарын менежмент, Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд хэтийн үүсэх эрсдлийг олж илрүүлэх, бууруулах, арилгах арга хэмжээ
2.	БОНЗ болон Хүлэмжийн хийн тооллого хийх сургалтад хэлтсийн ажилчдыг хамруулах	624,750	2026 оны 12 сар			Аюулгүй ажиллагааны бүрэн мэдлэг олгох сургалтууд
3.	Төслийн нийт ажилчдад байгаль орчны талаарх сургалт орох	Дотоот үйл ажиллагаа	2026 он 8-11 сар тухай бүр	Тогтвортой хөгжлийн газар (ТоХХ)	ТоХГ	
4	Төслийн талбайд ажлын байрны үзлэгийг тодорхой давтамжтай гүйцэтгэх	Дотоот үйл ажиллагаа	2026 оны 7 сараас	Тогтвортой хөгжлийн газар (ТоХХ)	ТоХГ	
5	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг гүйцэтгэх	17,000,000	2026 оны 12 сард	Тогтвортой хөгжлийн газар (ТоХХ)	ТоХГ	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн хүрээнд
	Нийт	Ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-с		Тогтвортой хөгжлийн хэлтэс (ТоХХ)	ТоХХ	

14 Биелэлтийг орон нутгийн оролцогч тал, оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг төслийн талбай орчмын оршин суугчид, оролцогч талуудад дараах байдлаар тайлагнаж, танилцуулга хийхээр төлөвлөж байна.

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал (төг)	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Төсөл хэрэгжих талбай орчмын айлууд	Биеэр болон цахим танилцуулна	Байгаль орчны арга хэмжээ Ажлын гүйцэтгэл	2026 оны 8-9 сар	Дотоод зардлаар	Компаний орон нутгийн мэдээллийн ажилтан	Төсөл хэрэгжих талбай орчмын айлууд
2	Орон нутгийн засаг захиргаа	Биеэр болон цахим танилцуулна	Ажлын гүйцэтгэл	2026 оны 12 сар	Дотоод зардлаар	Компаний орон нутгийн мэдээллийн ажилтан	Сумын захиргаа

15 “Тэрбум мод” хөтөлбөрийн мод тарих төлөвлөгөө

“Хургатай хайрхан” ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” аяныг дэмжин 10 сая мод тарих үүрэг хүлээж, энэхүү амлалтаа биелүүлэх зорилгоор төслийн харъяалагдах Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд мод үржүүлгийн газар байгуулж, үрээр болон харандаан суулгацаар төрөл бүрийн мод тарих туршилт хийж, шилжүүлэн суулгах суулгацыг үйлдвэрлэж байна. Энэхүү мод үржүүлгийн газарт 10 сая модны суулгацыг тарьж, бэлтгэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд тарьсан моддыг Овоотын коксжих нүүрсний төслийн лицензийн талбайн ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн дараах талбайд болон төлөвлөж буй Төслийн талбайгаас Эрдэнэт хотын төмөр замын дэд бүтцийн байгууламж хүртэлх замын барилга байгууламж дагуу тарьж ургуулах зорилготой юм. Үүнд тус төслийн талбай дотор баригдах бусад дэд бүтцийн талбай ч мөн хамрагдах юм.

Бид уурхайн олборлолт борлуулалтын үйл ажиллагаа эхлэхээр мод тарих ТЭЗҮ боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах төлөвлөгөөтэй байна. 2026 оны тухайд бид 10 сая мод тарьж ургуулах ТЭЗҮ боловсруулах ажлын албан даалгавар боловсруулж, батлуулах төлөвлөгөөтэй байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хавсралт

ХАВСРАЛТ : Аж ахуйн нэгжийн гэрчилгээ

УБ-2	Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.	
		
МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ 0000093467		
2006.12.21 / Бүртгэсэн он, сар, өдөр /	9019053077 / Улсын бүртгэлийн дугаар /	
5104424 / Регистрийн дугаар /		
Хургатайхайрхан Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани / Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /		
Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /		
Тушаал / шийдвэрийн нэр /	A-2488 / дугаар /	2006.12.21 / он, сар, өдөр /
4610 / код /	Гадаад худалдаа / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /	
0899 7490	Ашигт малтмалын ашиглалт 2042.08.10 хүртэл Ашигт малтмалын хайгуул хийх /2009.03.16-2018.03.16/	
/ код /		
/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /		
15.07.06~17.07.06 / хугацаа /	1 / гишүүдийн тоо /	424,541.50 / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /
Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, Алтай цамхаг 3-р давхарт 302, Утас1: 70116828, Утас2: 70116826, Факс: / хуулийн этгээдийн албан ёсны хаяг /		
Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлийн газар / бүртгэсэн байгууллагын нэр /		
Гэрчилгээг дөхчин олгосон 2015 он 5 сар 4 өдөр		

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ



ХУРГАТАЙ
ХАЙРХАН

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ 2026 | 24

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар **MV-017098**

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Хөвсгөл аймаг /хот/-ийн
Цэцэрлэг сум /дүүрэг/-ын
Овоот нэртэй газарт орших
5758.70 гектар талбай бүхий уурхайн талбайд
хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг
зөвшөөрч улсын бүртгэлийн 9019053077 тоот гэрчилгээтэй
“Хургатайхайрхан” ХХК-ийн бүртгэлийн № 1620-д
энэхүү тусгай зөвшөөрлийг 2042.08.10 дуустал
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хуулигүй.

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЭНХТУЛГА

2012 оны 8 сарын 10 өдөр
Улаанбаатар хот

**Өмнөх онд ашиглалт эхлээгүй, үйл ажиллагаа
явуулаагүй тухай тодорхойлолт**



**ХУРГАТАЙ
ХАЙРХАН**

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ 2026 | 25




**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

Засаг Даргын Тамгын Газрын байр, 5 дугаар баг,
Цэцэрлэг сум, Хөвсгөл аймаг, 67320
Цахим шуудан: tsetserlegzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.tsetserleg.khs.gov.mn

2025.10.20 № 1/300
танай _____ -ны № _____ -т

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН
ХЭЛТЭСТ**

Тус сумын Ренчинжугнай багийн нутагт орших
“Хургатай хайрхан” ХХК нь 2025 онд ашигт малтмал
олборлох үйл ажиллагаа явуулаагүй нь үнэн болно.



Ч.ДАШДАВАА

675885139

2026 оны уулын ажлын төлөвлөгөө



**ХУРГАТАЙ
ХАЙРХАН**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ 2026 | 26**

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2022 оны 12 дугаар сарын ний өдрийн
..... дүгээр тушвалын хоёрдугаар хавсралт

Батлав:

Хургатайхайрхан ХХК-ийн
захирал /Д.Ачитэрдэнэ /



Хүлээн авсан:


АМГТГ-ын Уул уурхайн хэлтсийн
дарга /П.Зоригт /



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ОВООТ ОРДЫН 2026 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



Ашигт малтмалын төрөл: Чулуун
Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-017098
Нэмэлт АТЗ-ийн дугаар:



Танилцсан: Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн

..... /П.Зоригт/

БОЛОВСРУУЛСАН:

1. Ерөнхий инженер
2. Уулын инженер
3. Баяжуулагч инженер
4. Механик инженер
5. Эдийн засагч

.....
.....
.....
.....

2026 он



ХУРГАТАЙ
ХАЙРХАН